



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/735

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а, 29.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд Аж ахуй нэгжийн ээлжит тооллого зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан Ховд аймгийн аж ахуй нэгж, хувиараа бизнес эрхлэгчдийн тооллого хийх ажлыг эрчимжүүлэх зорилгоор тоологч нэмж ажиллуулахад шаардагдах 3 831 400 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 3 831 400 төгрөг/гурван сая найман зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун/-ийг аймгийн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 5.8-д Худалдаа аж үйлдвэрийн танхимын бизнесменүүдийн үйл ажиллагааг дэмжиж сурталчлах хөтөлбөр, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 2977
D/Zah-A/735-Bo

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 01-ний өдрийн
А/735 дугаар захирамжийн хавсралт

Аж ахуйн нэгж байгууллагын тооллого явуулахтай холбогдон гарах зардлын тооцоо

Сум	Тоологч урамшуулал				Унааны зардал				Тооллогын тайлан /үр дүнгийн ном/			Бүгд дүн
	Тоологч ийн тоо	Ажил лах өдөр	Нэгжийн үнэ	Нийт дүн	Тоологчийн тоо	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ /литр/	Нийт дүн	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Үнийн дүн /төгрөг/	
Жаргалант	7	30	5500	1155000	7	2520	10	176400	25000	100	2500000	3 831 400

-оОо-